



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2023 оны 08 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар А/419

Улаанбаатар хот

**СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ҮЙЛЧЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ АВАХ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АНГИЛАЛ, ТАВИГДАХ ШААРДЛАГЫГ БАТЛАХ ТУХАЙ**

Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.6 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

- 1.Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөл авах үйлчилгээний ангиллыг нэгдүгээр хавсралтаар, тавигдах шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналтын газар (Б.Санчирдорж)-т даалгасугай.
3. Энэхүү тушаалыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх арга хэмжээ авахыг хуулийн хэлтэс (Э.Цолмонжаргал)-т үүрэг болгосугай.

САЙД Х.БОЛОРЧУЛУУН